



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/39

Модот

**Хяналт тавих ажлын хэсэг байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 20 дугаар зүйлийн 20.1.18, 22 дугаар зүйлийн 22.1.17, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Тус суманд Эрүүл мэндийн яамны хөрөнгөөр өргөтгөлийн барилга, эмчийн байрны ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд

Ажлын хэсгийн ахлагч О.Батбаяр - Төрийн сан, төлбөр тооцооны мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга Ц.Сэвжид - Эрүүл мэндийн төвийн даргын түр орлон
гүйцэтгэгч

Гишүүд И.Найманцэцэг - Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
А.Гансүх - Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны
асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Оюунбаяр - ИТХ, соёл хариуцсан нягтлан бодогч

2.Өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэлийн шат бүрт хяналт тавих, тэмдэглэл хөтлөх, фото зурагаар баримтжуулах, чанаргүй хийгдсэн ажлыг албан шаардлага хүргүүлж засуулах, тухай бүр удирдлагад шуурхай танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (О.Батбаяр)-т даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

